



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 онь 05 сарын 11 өдөр

Дугаар А/296

Номгон

Аймгийн хэмжээний эвдэрсэн газрын  
тооллого хийх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/71 дугаар "Удирдамж батлах тухай" тушаал, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний 2/8 дугаар тогтоолоор баталсан "Аймгийн 2021 оны төлөвлөгөө"-ний 56 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уул уурхайн ашиглалт болон хувиараа ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж орхигдсон газрын тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, эвдэрсэн газрын тооллогын ажилд зарцуулагдах хөрөнгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эвдэрсэн газрын тооллогыг мэргэжлийн өндөр түвшинд, үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсэг (Э.Ганзориг)-т үүрэг болгосугай.

3. Уул уурхайн ашиглалт, хувиараа ашигт малтмалын олборлогч иргэд болон бусад үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж орхигдсон газрын тооллогод хамрагдах талбайн судалгаа, маршрутыг гаргаж холбогдох албан тушаалтнуудыг оролцуулахыг Сумдын засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Шаардагдах зардлыг Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д, Ажлын хэсгийн гишүүдийн томилолтын зардлыг шийдвэрлэж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Д.Бямбадорж), Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга (Д.Алтангэрэл), Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Ганзориг), Бөөнцагаан – Орог нуурын сав газрын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч


2.

(Г.Хүрэлсүх), Ус цаг, уур орчны шинжилгээний төвийн дарга (Ч.Оюунчимэг) нарт тус тус үүрэг болгосугай.

5. Хээрийн хэмжилтийн ажлыг 06 дугаар сарын 01-ний өдрөөс 1 сарын хугацаанд хийж, суурин боловсруулалтын ажлыг 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор мэдээллийн санд оруулж, гүйцэтгэлийн тайланг 2021 оны 10 дугаар сарын 10-ны дотор холбогдох газруудад хүргүүлэхийг ажлын хэсэг (Э.Ганзориг)-т даалгасугай.


6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021.05.05 дугаар  
сарын 11-ний өдрийн А/296 дугаар  
захирэмжийн дүгээр хавсралт



АЙМГИЙН ХЭМЖЭЭНИЙ ЭВДЭРСЭН ГАЗРЫН  
ТООЛЛОГО ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Э.Ганзориг -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Б. Наранбаатар – Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Газар, газрын хэвлийн байгаль орчны хяналт үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

Ц.Уянга – Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, газар, геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Отгончимэг - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн

Э.Жамц - Бөөнцагаан - Орог нуурын сав газрын захиргааны усны Барилга байгууламж, үйлдвэр, хөдөө аж ахуйн усны ашиглалт хариуцсан мэргэжилтэн

Б.Бэхбат - Бөөнцагаан - Орог нуурын сав газрын захиргааны Газарзүйн мэдээлэл, усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн


Ж.Эрдэнэбилэг - Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн Хөдөө аж ахуйн технологич инженер

Б.Дайрийсүрэн – Ус цаг уур орчны шинжилгээний төвийн Хөдөө аж ахуйн ахлах техникч

Сумын Засаг дарга, Байгаль орчны хяналтын Улсын байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал нар

Нарийн бичиг: Б.Намуун – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

оОо



Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын  
11-ний өдрийн А/296 дугаар Захирамжийн 2 дугаар  
хавсралт

АЙМГИЙН ЭВДЭРСЭН ГАЗРЫН ТООЛЛОГЫН АЖИЛД  
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Нэр бүхий 17 сумын 224 нэгж талбарын 729,4 га талбай

Үүнээс: эзэн холбогдох нь тодорхойгүй 98 нэгж талбарын 401,8 га талбай

Эзэн холбогдогч нь тодорхой 126 нэгж талбарын 251,07 га талбайн

17 сумын нутаг дэвсгэрийг хамарсан 4184 км

Д/д	Очих сумын нэр	Очих сумын нэр	Км	Тайлбар
1	Өлзийт	Богд	112	
2	Богд	Баянлиг	106	
3	Баянлиг	Баянговь	45	
4	Баянговь	Шинэжинст	110	
5	Шинэжинст	Баян – Өндөр	65	
6	Баян - Өндөр	Баацагаан	145	
7	Баацагаан	Бөмбөгөр	110	
8	Бөмбөгөр	Бууцагаан	80	
9	Бууцагаан	Хүрээмал	45	
10	Хүрээмарал	Гурванбулаг	100	
11	Гурванбулаг	Заг	90	
12	Заг	Жаргалант	30	
13	Жаргалант	Галуут	90	
14	Галуут	Эрдэнэцогт	70	
15	Эрдэнэцогт	Баянхонгор	30	
			<b>1318+4184</b>	<b>5502 км явах</b>

ТООЛЛОГЫН АЖИЛД ШААРДАГДАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ТОМИЛОЛТ, ШАТАХУУН БУСАД ЗАРДАЛ

1. Тоног төхөөрөмж

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Notebook /dell i7/	2ш	2,300,000	4,600,000
2	Газар зүйн мэдээлэлийн системийн программ	1ш	7,000,000	7,000,000
3	GPS /Garmin GPSMAP64sc/	1ш	1,250,000	1,250,000
	<b>Нийт</b>			<b>12,850,000</b>

2. Томилолт

№	Нэрс	Албан тушаал	Нэг хоногийн томилолт	Ажиллах хоног	Нийт
1	Э.Ганзориг	БОАЖГ-ын дарга	26,500	30	795,000
2	Б.Наранбаатар	БОАЖГ-ын ахлах мэргэжилтэн	26,500	30	795,000
3	Д.Намуун	ХОХБТХ-ийн мэргэжилтэн	26,500	30	795,000
4	Ц.Уянга	МХГ-ын БОХУБ	26,500	30	795,000
5	Б.Отгончимэг	ГХБХБГ-ын мэргэжилтэн	26,500	30	795,000
6	Э.Жамц	БЦОНСГЗ-ны мэргэжилтэн	26,500	30	795,000
7	Б.Бэхбат	БЦОНСГЗ-ны мэргэжилтэн	26,500	30	795,000
8	Ж.Эрдэнэбилэг	УЦУОШГ-ын инженер	26,500	30	795,000
9	Б.Дайрийсүрэн	УЦУОШГ-ын ХАА-н ахлах техникч	26,500	30	795,000
10	Д.Батбаатар	БОАЖГ-ын жолооч	26,500	30	795,000
11		Жолооч	26,500	30	795,000
	<b>Нийт</b>				<b>8,745,000</b>

### 3. Тээвэр, шатахууны зардал

№	Явах км /ирэх буцах/	Үндсэн норм /литр/	Зарцуулах шатахуун /литр/	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
8878 БНА	5502км	20 литр	1100,4 литр	2,100	<b>2,310,840</b>

Жич: Нийт 17 сумд 5502км явна гэж тооцсон

### 4. Бусад зардал /Бичиг хэрэг/

Д/д	Бараа материалын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Бичгийн цаас	5 боодол	12,500	62,500
2	Принтрийн хор /өнгөт/	1 ком	180,000	180,000
3	Инк цаас	3 боодол	12,000	36,000
4	Бал	20ш	500	10,000
5	GP батерей	40ш	1,000	40,000
6	Метр /50м/	1ш	60,000	60,000
	<b>Нийт</b>			<b>388,500</b>

### Нийт зардлын тооцоо

Д/д	Зардлын нэр	Нийт
1	Тоног төхөөрөмж	12,850,000
2	Томилолт	8,745,000
3	Шатахуун	2,310,840
4	Бусад зардал	388,500
	<b>Нийт</b>	<b>24,294,340</b>
	<b>Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө</b>	<b>15,549,340</b>
	<b>Албан байгууллагууд</b>	<b>8,745,000</b>